ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021-/1/-СТА-ТӨҮГ**


Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал

Утас:70350757

Цахим хаяг:azjargalb@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....................5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....................10
3.Аудитын тайлан....................10
3.1. Ерөнхий зүйл....................10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....................11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....................11
3.4. Материаллаг байдал ....................11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....................12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....................13
3.7. Шилэн дансны мэдээлэл....................14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................14
3.9. Аудитын илрүүлэлт....................14
Залруулсан алдаа....................14
Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй болно. ....................14
Аудитын зөвлөмж....................14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....................15
4. Менежментийн захидал....................15
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....................18

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021. 02. 25 № 52
танай________-ны № ________-т

ОРХОН АЙМГИЙН
АВТОТЭЭВРИЙН ТӨВИЙН ДАРГА
Г.ЯДМАА ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 63,754,645.97 | 65,080,149.87 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 2,715,204.27 | 60,027.90 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 1,875,097.56 | - |
| 31110 | Төгрөг | 1,875,097.56 | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 840,106.71 | 60,027.90 |
| 3121 | Төгрөг | 840,106.71 | 60,027.90 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 840,106.71 | 60,027.90 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 31,314,391.00 | 31,314,391.00 |
| 34400 | Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар | 31,314,391.00 | 31,314,391.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 29,725,050.70 | 33,705,730.97 |
| 351 | Түүхий эд материал | 5,841,722.99 | 5,529,689.48 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,841,722.99 | 5,529,689.48 |
| 354 | Хангамжийн материал | 23,883,327.71 | 28,176,041.49 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 268,227.27 | 410,499.99 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,643,999.91 | 3,744,587.79 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 9,566,784.98 | 10,020,092.71 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 163,636.36 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,404,315.55 | 13,837,224.64 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 902,898,269.11 | 900,796,187.71 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 902,898,269.11 | 900,796,187.71 |
| 392 | Биет хөрөнгө | 709,458,269.11 | 707,356,187.71 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 630,024,221.87 | 572,045,389.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (15,957,159.12) | (27,380,097.37) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 91,873,580.00 | 61,921,121.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (62,396,357.68) | (61,921,121.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 172,434,413.00 | 133,253,845.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (127,630,213.45) | (107,167,465.03) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,465,613.30 | 17,205,613.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,133,274.20) | (8,509,998.42) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,572,836.00 | 127,908,900.58 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,795,390.61) | |
| 393 | Биет бус хөрөнгө | 193,440,000.00 | 193,440,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 193,440,000.00 | 193,440,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 966,652,915.08 | 965,876,337.58 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 966,652,915.08 | 924,553,176.41 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 966,652,915.08 | 924,553,176.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 587,342,457.84 | 488,560,301.12 |
| 51101 | Өмч: - төрийн | 587,342,457.84 | 488,560,301.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 379,310,457.24 | 435,992,875.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 379,310,457.24 | 379,310,457.24 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 56,682,418.05 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 966,652,915.08 | 924,553,176.41 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 530,141,221.31 | 485,207,495.68 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 518,077,600.21 | 473,564,024.54 |
| 110 | Орлогын албан татвар | 518,077,600.21 | 473,564,024.54 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 518,077,600.21 | 473,564,024.54 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 518,077,600.21 | 473,564,024.54 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,063,621.10 | 11,643,471.14 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 12,063,621.10 | 11,643,471.14 |
| 120002 | Хүүгийн орлого | 768,716.10 | 123,898.45 |
| 120005 | Түрээсийн орлого | 10,999,999.90 | 11,372,727.18 |
| 120009 | Бусад орлого | 294,905.10 | 146,845.51 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 409,494,360.45 | 428,525,077.63 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 409,494,360.45 | 428,525,077.63 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 408,199,360.45 | 426,875,077.63 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279,942,325.97 | 303,541,770.19 |
| 210101 | Үндсэн цалин | 260,810,325.97 | 287,330,270.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,132,000.00 | 16,211,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,226,270.40 | 40,916,250.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,957,281.36 | 25,762,083.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,443,038.26 | 2,424,666.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,107,595.61 | 6,061,666.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 610,759.56 | 606,166.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,107,595.61 | 6,061,666.78 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,198,387.40 | 19,627,147.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,673,714.52 | 3,273,334.55 |
| 210302 | Түлш, халаалт | 5,539,979.54 | 6,614,466.36 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 970,656.90 | 1,616,553.56 |
| 210304 | Байрны түрээс | 8,014,036.44 | 8,122,792.78 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,541,377.21 | 7,216,813.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,390,000.01 | 1,959,931.57 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,386,000.02 | 2,375,076.36 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,712,877.18 | 2,689,805.30 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 52,500.00 | 192,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,109,118.20 | 10,505,878.55 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,764,390.92 | 10,024,060.37 |
| 210604 | Урсгал засвар | 7,344,727.28 | 481,818.18 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 768,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | - | 768,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,822,878.20 | 11,067,031.01 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,171,230.00 | 364,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 142,560.00 | 213,840.00 |
| 210807 | Газрын төлбөр | 290,160.00 | 290,160.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 302,673.22 | 420,913.50 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,437,754.98 | 1,975,817.51 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | 5,030,000.00 | 3,080,000.00 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 3,448,500.00 | 4,722,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,359,003.07 | 33,232,186.60 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,359,003.07 | 33,232,186.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,295,000.00 | 1,650,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,295,000.00 | 1,650,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,295,000.00 | 1,650,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 120,646,860.86 | 56,682,418.05 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 120,646,860.86 | 56,682,418.05 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,987,140,168.96 | 1,419,073,610.65 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,563,214,346.96 | 1,017,951,272.00 |
| 110 | Орлогын албан татвар | 1,563,214,346.96 | 1,017,951,272.00 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,563,214,346.96 | 1,017,951,272.00 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 557,325,264.96 | 493,266,680.00 |
| 110008 | Шууд бус орлого | 1,005,889,082.00 | 524,684,592.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 423,925,822.00 | 401,122,338.65 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 423,925,822.00 | 401,122,338.65 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 411,825,822.00 | 389,822,338.65 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 411,825,822.00 | 389,822,338.65 |
| 120005 | Түрээсийн орлого | 12,100,000.00 | 11,300,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,006,066,977.04 | 1,421,852,685.47 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,006,066,977.04 | 1,421,852,685.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 398,709,699.65 | 390,523,276.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 303,527,370.93 | 303,501,520.19 |
| 210101 | Үндсэн цалин | 251,886,090.20 | 277,634,603.82 |
| 210102 | Нэмэгдэл | 29,969,280.73 | 9,655,416.37 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,672,000.00 | 16,211,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,434,541.93 | 40,916,250.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,434,541.93 | 40,916,250.80 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,619,570.64 | 21,290,309.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,941,085.94 | 3,600,668.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,750,413.30 | 7,275,912.79 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,357,671.40 | 1,778,209.11 |
| 210304 | Байрны түрээс | 8,570,400.00 | 8,635,520.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,235,461.26 | 4,829,619.84 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,206,000.00 | 1,029,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,853,596.36 | 2,792,584.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,378,164.90 | 1,007,385.84 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 797,700.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,699,163.64 | 10,176,002.56 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,414,963.64 | 10,176,002.56 |
| 210604 | Урсгал засвар | 7,284,200.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,130,000.00 | 1,648,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 768,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 3,130,000.00 | 880,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,163,591.25 | 5,881,573.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,217,530.00 | 448,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 50,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 290,160.00 | 290,160.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 297,173.22 | 420,913.50 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 5,166,168.03 | 4,722,000.00 |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/ | 142,560.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,900,000.00 | 2,280,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,900,000.00 | 2,280,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,607,357,277.39 | 1,031,329,408.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,295,000.00 | 1,590,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,295,000.00 | 1,590,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 590,173,195.39 | 506,099,816.68 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 590,173,195.39 | 506,099,816.68 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,005,889,082.00 | 523,639,592.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,005,889,082.00 | 523,639,592.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (18,926,808.08) | (2,779,074.82) |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 768,716.10 | 123,898.45 |
| 140007 | Хүлээн авсан хүүний орлого | 768,716.10 | 123,898.45 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 768,716.10 | 123,898.45 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (18,158,091.98) | (2,655,176.37) |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 20,873,296.25 | 2,715,204.27 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,715,204.27 | 60,027.90 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 683,008,340.20 | 296,034,721.38 | 979,043,061.58 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -95,665,882.36 | | -95,665,882.36 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 587,342,457.84 | 296,034,721.38 | 883,377,179.22 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | 83,275,735.86 | 83,275,735.86 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 587,342,457.84 | 379,310,457.24 | 966,652,915.08 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 587,342,457.84 | 379,310,457.24 | 966,652,915.08 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 587,342,457.84 | 379,310,457.24 | 966,652,915.08 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | -98,782,156.72 | | -98,782,156.72 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | 56,682,418.05 | 56,682,418.05 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 488,560,301.12 | 435,992,875.29 | 924,553,176.41 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 456,376,073.00 | 392,113,276.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 456,376,073.00 | 392,113,276.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 456,376,073.00 | 390,523,276.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 356,295,800.00 | 303,501,520.19 |
| 210101 | Үндсэн цалин | 295,332,000.00 | 277,634,603.82 |
| 210102 | Нэмэгдэл | 39,549,800.00 | 9,655,416.37 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,414,000.00 | 16,211,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,099,933.00 | 40,916,250.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,099,933.00 | 40,916,250.80 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,581,080.00 | 21,290,309.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,420,640.00 | 3,600,668.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,470,000.00 | 7,275,912.79 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,286,040.00 | 1,778,209.11 |
| 210304 | Байрны түрээс | 9,404,400.00 | 8,635,520.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,700,000.00 | 4,829,619.84 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,400,000.00 | 1,029,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,760,000.00 | 2,792,584.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,240,000.00 | 1,007,385.84 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,840,000.00 | 10,176,002.56 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,840,000.00 | 10,176,002.56 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,718,500.00 | 1,648,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 238,500.00 | 768,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 3,480,000.00 | 880,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,860,760.00 | 5,881,573.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,974,000.00 | 448,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,722,000.00 | 4,722,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 134,600.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 290,160.00 | 290,160.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300,000.00 | 420,913.50 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,440,000.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,280,000.00 | 2,280,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,280,000.00 | 2,280,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 1,590,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 1,590,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,590,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 389,822,338.65 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | - | 389,822,338.65 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 389,822,338.65 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 2,715,204.27 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 60,027.90 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Ядмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 15-наас 2021 оны 03 дугаар сарын 15–ны хооронд Орхон аймгийн төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, аудитор Б.Азжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн төрийн аудитын газарт 2021 оны 02 сарын 25-ний өдрийн 113 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Автотээврийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь:

Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаын гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангахад оршино.

Автотээврийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Техникийн хяналтын үзлэгийг хуулийн хугацаанд гүйцэтгэх
- Тээврийн хэрэгслийн улсын дугаар олгох, шилжилт хөдөлгөөн хийх авто тээвэртэй холбоотой үйлчилгээг иргэн, аж ахуй нэгжүүдэд үзүүлэх
- Хот хооронд болон орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах
- Мэргэшсэн жолоочийн шалгалт авч , үнэмлэх олгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, дүрэм журам. Үүнд:

Автотээврийн тухай хууль
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
Автотээврийн Үндэсний төвийн даргын тушаал, журам
Бусад хууль тогтоомжууд

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Автотээврийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10 дугаар сарын 30-ны санхүүгийн тайлангийн нийт орлого 443,864.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,438.6 мянган төгрөгөөр

тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлого 485,207.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,852.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Автотээврийн төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,099.7 мянган төгрөгөөр буюу 14.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,715.2 | 60.0 | -2,655.2 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 31,314.4 | 31,314.4 | 0 |
| Бараа материал | 29,725.0 | 33,705.7 | 3,980.7 |
| Үндсэн хөрөнгө | 709,458.3 | 666,033.0 | -43,425.0 |
| **Нийт хөрөнгө** | 966,652.9 | 924,553.2 | -42,099.7 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 966,652.9 | 924,553.2 | -42,099.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 966,652.9 | 924,553.2 | -42,099.7 |

Бараа материалын дансны үлдэгдэл 33,705.7 мянган төгрөг болж 3,980.7 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал болон хангамжийн материалыг АТҮТөвөөс хоорондын тооцоогоор шилжүүлэн авсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 666,033.0 мянган төгрөг болж 43,425.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд АТҮТөв рүү Соната-8 маркийн суудлын автомашин хоорондын тооцоогоор шилжүүлсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс үнэ төлбөргүй шилжиж ирсэн 24,747.5 мянган төгрөгийн өртөгтэй, 24,747.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй суудлын автомашиныг АТҮТөвөөс шилжүүлэн авсанаас шалтгаалсан байна.

Орхон аймгийн Автотээврийн төв нь нийт 531,829.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 485,083.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 8.8 хувиар тасарсан байна. Энэ нь улс орон нутгийг хамарсан COVID-19 цар тахлаас шалтгаалсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг байдлын өөрчлөлт гарсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 531,829.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагч тухайн байгууллагын төсвийн төслийг 492,840.71 мянган төгрөгөөр баталж зарцуулах эрх олгосон байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 492,840.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 466,548.7 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд 26,292.0 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчид буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Улсын  төсөвт төвлөрүүлэх орлого

Тус байгууллага нь улсын төсөвт  531,829.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 485,083.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 91.2 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 2* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Техникийн хяналтын үзлэг | 342,000.0 | 382,236.1 | 40,236.1 | 111.7 |
| Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн 8% | 125,229.2 | 47,828.6 | -77,400.6 | -26.2 |
| Орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн 4% | 20,000.0 | 16,978.1 | -3,021.9 | -11.8 |
| Түрээсийн орлого | 12,000.0 | 11,372.7 | -627.3 | -10.5 |
| Бүртгэлийн үйлчилгээний орлого | 32,600.0 | 26,341.09 | -6,259.0 | -12.4 |
| Гэрлийн тусгал өөрчлөх орлого | | 180.0 | 180.0 | |
| Бусад орлого | | | | |
| **Нийт орлогын дүн** | 531,829.2 | 485,083.39 | 46,745.81 | 8.8 |

Үндсэн үйл ажиллагааны орлого 46,745.81 мянган төгрөгөөр тасарсан шалтгаан нь Улсын болон орон нутгийн сонгууль, мөн ковид-19 өвчний тархалтаас шалтгаалан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосны улмаас 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдөр хүртэл тус төвийн үйл ажиллагаа бүрэн зогссонтой холбоотой байна.

**Нэмэлт санхүүжилт**

Орхон аймгийн Автотээврийн төв нь нэмэлт санхүүжилтийн дансгүй болно.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Орхон аймгийн Автотээврийн төвд 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 3 зөвлөмж  100 хувийн хэрэгжилттэй байна.

*Хүснэгт 3*  Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 16,583.7 | 1 | 16,583.7 | | | |
| Зөвлөмж | 3 | 4,442.9 | 3 | 4,442.9 | | | |
| **Нийт дүн** | **4** | **21,026.6** | **4** | **21,026.6** | | | |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,081.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 3,081.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил гараагүй болно.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар нийт илэрсэн 3,081.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 3,081.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Орхон аймгийн Автотээврийн төвд үнэт цаас болон эд хөрөнгийн тооллого хийх шаардлагатай гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Зардлын данстай холбоотой асуудал**

**1.1. <u>Илрүүлэлт:</u>**

Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй баримтаар 502.0 мянган төгрөгийн шатахууныг илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухайхуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан “жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын “автомашины 100 км гүйлтэд зарцуулах жишиг норм”-той нийцэхгүй байна.

**1.2. <u>Эрсдэл:</u>**

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

**1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>:**

Автомашины шатахуун зарцуулалтын хэмжээг туршилт хийж баталгаажуулж, бодит зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж, шатахууныг зарцуулах.

**2. <u>Илрүүлэлт:</u>**

Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 289.4 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 347-р тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягтыг нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

**2.1. <u>Эрсдэл:</u>**

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

2.2. **<u>Өгсөн зөвлөмж</u>:**

Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

3. **<u>Илрүүлэлт:</u>**

Тус байгууллага нь харилцах данснаасаа мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 276 тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3-д" төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянга) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөгөөс хэтрэхгүй байна", Сангийн сайдын 347 дугаар тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягтыг нөхөх заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

**3.1. <u>Эрсдэл:</u>**

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

**3.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:**

Бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулж зарлага гаргахдаа Сангийн сайдын 276 тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3-г хэрэгжүүлж ажиллах.

**3.3. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>**

Төсвийн захирагчийн 2021.03.15-ны өдрийн 165 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

| | | |
|---|---|---|
| Бэлтгэсэн: Аудитор | Б.Азжаргал | Огноо |
| Анхан шатанд хянасан: Аудитын менежер | Б.Эрдэнэ | Огноо |
| Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор | Ц.Нармандах | Огноо |

Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

3. **Илрүүлэлт:**

Тус байгууллага нь харилцах данснаасаа мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 276 тушаалаар батлагдсан мөнгөн кассын журмын 6.3-д" төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянга) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөгөөс хэтрэхгүй байна", Сангийн сайдын 347 дугаар тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягтыг нөхөх заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

**3.1. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулж зарлага гаргахдаа Сангийн сайдын 276 тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3-г хэрэгжүүлж ажиллах.

**3.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Төсвийн захирагчийн 2021.03.15-ны өдрийн 165 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо

## Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.10

Аудитын нэр: Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код: ОРА-2021/1/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр: Орхон аймгийн Автотээврийн төв

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй баримтаар шатахууныг илүү тооцож олгосон байна. | 502.3 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Г.Ядмаа Б.Дэлгэрсайхан |
| 2 | Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй | 289.4 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Г.Ядмаа Б.Дэлгэрсайхан |
| 3 | Тус байгууллага нь харилцах данснаасаа мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна. | 2,290.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Г.Ядмаа Б.Дэлгэрсайхан |
| **ДҮН** | | **3,081.7** | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо

Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Орхон аймгийн Автотээврийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021.03.10 | | | ОРА-2021/1/СТА-ТӨҮГ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Орхон аймгийн Автотээврийн төв | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй баримтаар шатахууныг илүү тооцож олгосон байна. | 502.3 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Г.Ядмаа Б.Дэлгэрсайхан |
| 2 | Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй | 289.4 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Г.Ядмаа Б.Дэлгэрсайхан |
| 3 | Тус байгууллага нь харилцах данснаасаа мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна. | 2,290.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Г.Ядмаа Б.Дэлгэрсайхан |
| | **ДҮН** | **3,081.7** | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо 10/10

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо 2021.03.10

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо

6117143690
ФАА0073 9042806

ОРА-2021-/1/-СТА-ТӨҮГ 15